

**Монголын эрх зүйн түүх судлал: Хууль цаазын эх
сурвалжийн судалгааны өнөөгийн байдал,
тулгамдсан асуудал**

**Mongolian Legal History Studies: The Current State of Research
on Historical Legal Sources and Contemporary Challenges**

Баянбаатарын Батбаяр

<https://orcid.org/0009-0006-9902-0600>

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор*

Улаанбаатар хот, Монгол Улс

batbayar_b@num.edu.mn

© B.Batbayar, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Энэхүү өгүүлэлд Монголын эрх зүйн түүх судлалын өнөөгийн төлөв байдал, судалгааны чиг хандлага, анхаарах зарим асуудлыг уламжлалт хууль цаазын эх сурвалжийн судалгаанд тулгуурлан шинжилжээ. Судалгааны хүрээнд эрх зүйн түүх судлалын онцлог, түүний сурвалж судлал, эх бичиг судлал болон бусад хавсарга ухаантай уялдах холбоог тодруулж, хууль цаазын эх сурвалжийн суурь судалгааны ач холбогдлыг авч үзэв. Үүний зэрэгцээ Монголын хууль цаазын гол эх сурвалжуудын судалгааны үр дүн, хүрсэн түвшнийг тоймлон дүгнэж, зарим эх сурвалжийн судалгаанд илэрч буй арга зүйн асуудлыг тодорхой жишээгээр авч үзэв. Түүнчлэн эрх зүйн түүхийн судалгааны өнөөгийн хандлагыг үнэлж, эх сурвалжийн иж бүрэн шинжилгээ, салбар хоорондын хамтын судалгаа, салбар эрх зүйн түвшний нарийвчилсан эрх зүйн судалгааг цаашид эрчимжүүлэх шаардлагатайг онцоллоо. Судалгааны дүнд Монголын эрх зүйн түүх судлалын суурь үндэс нэгэнт бүрдсэн боловч онол, арга зүй, эх сурвалжийн бодитой, хэрэглээний чиглэлийн гүнзгийрүүлсэн судалгааг шинэ шатанд гаргах хэрэгцээ байгааг санал болгов.

[Түлхүүр үг]

Монголын эрх зүйн түүх, уламжлалт хууль цааз, хууль цаазын эх сурвалж, сурвалж судлал, эх бичиг судлал, эрх зүйн түүхийн судалгаа.

1. Оршил

Эрх зүйн түүх судлал нь үндэсний эрх зүйн тогтолцооны хөгжил, хувьсал, уламжлал, үзэл санаа, хэм хэмжээ, институтийн бүрэлдэл, өөрчлөлтийг түүхэн хөгжилтэй нь уялдуулан авч үздэг хууль зүйн шинжлэх ухааны суурь чиглэлийн нэг мөн. Энэ утгаараа эрх зүйн түүх судлал нь Үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй зэрэг материаллаг болон процессын эрх зүйн салбаруудтай төдийгүй эрх зүйн онол, төрийн онол, эрх зүйн философи, харьцуулсан эрх зүй зэрэг онолын шинжтэй судлагдахууны хүрээтэй нягт холбогдон хөгждөг. Түүнчлэн эрх зүйн дэд салбар, тодорхой институт, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн соёл, эрх зүйн ухамсар зэрэг асуудлыг ч мөн энэ хүрээнд авч үзэх боломжтой. Иймээс эрх зүйн түүх судлалын хамрах хүрээ өргөн, агуулгын хувьд олон түвшинд задлан шинжлэх боломжтой судлагдахуун болох нь харагдана.

Эрх зүйн түүх судлалд уламжлалт хууль цаазын эх сурвалжийн суурь судалгаа онцгой байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хөгжлийн түүхийг бодитой, шинжлэх ухааны үндэстэйгээр тодорхойлохын тулд тухайн цаг үеийн хууль цаазын эх сурвалжийг зөв таньж тодорхойлох, эх бичгийн онцлогийг нягтлах, утга агуулгыг задлан шинжлэх, түүхэн нөхцөлтэй нь холбон тайлбарлах шаардлага гардаг. Ийм суурь судалгаагүйгээр эрх зүйн түүхийн хөгжлийн чиг хандлага, онцлог, дотоод логикийг тодорхойлох боломж хязгаарлагдмал юм. Нөгөө талаар, эх сурвалжийн суурь судалгаанд тулгуурлаж байж л тодорхой салбар эрх зүй, эрх зүйн институт, хэм хэмжээ, эрх зүйн үзэл санааг нарийвчлан судлах нөхцөл бүрдэнэ.

Иймд энэхүү өгүүлэлд эрх зүйн түүх судлалд сурвалж судлал, эх бичиг судлал зэрэг хавсарга ухааны эзлэх байр суурийг тодруулж, Монголын уламжлалт хууль цаазын судалгааны үр дүн, хүрсэн түвшнийг үнэлэн дүгнэж, хууль цаазын эх сурвалжийн суурь судалгаанд анхаарах шаардлагатай зарим асуудлыг хөндөн авч үзнэ. Үүний зэрэгцээ Монголын эрх зүйн түүх судлалын өнөөгийн чиг хандлага, тулгамдсан асуудлыг тодорхойлж, цаашдын судалгааны зорилт, боломжит чиглэлийн талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

2. Бусад салбар ухаан эрх зүйн түүх судлалд холбогдох нь

Эрх зүйн түүх судлал түүхийн шинжлэх ухаанд хамаарах уу?, хууль зүйн шинжлэх ухаанд хамаарах уу? гэдэг асуулт олон жилийн турш судлаачдын дунд маргааны сэдэв болсоор ирсэн. Өдгөө энэ салбарыг хууль зүйн шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг мөн

хэмээн үзэх хандлага давамгайлж буй боловч түүхийн шинжлэх ухааны хүрээнд хамаатуулан авч үздэг нэг бус судлаачид¹ бий. Түүнчлэн *эрх зүйн түүх бол хоёр өөр шинжлэх ухааныг нэгтгэх оролдлогын үр дүн*² гэж үздэг хандлага ч буй бөгөөд энэ үүднээсээ *эрх зүйн түүхийн тухайд шинжлэх ухааны салбар хоорондох олон удаагийн эмх цэгцтэй төлөвлөсөн “гэрлэлтүүд” буюу “холбон судлах үйл явц”-ын үр дүнд бий болсон зүйл*³ гэж тодорхойлсон байдаг. Энэ үүднээс авч үзвэл эрх зүйн түүх судлал нь олон салбарын шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, судалгааны уламжлалын огтлолцлоос бүрэлдэн тогтсон цогц судалгааны чиглэл гэж хэлж болно.

Энэ хүрээнд эрх зүйн түүх судлалтай шууд холбогдох салбарын нэг нь сурвалж судлал мөн. *Сурвалж судлал нь түүхэн эх сурвалжийг (гол төлөв бичгийн) хэрхэн судлах, ашиглах, онол-арга зүйг боловсруулдаг түүхийн салбар ухааны нэг чиглэл юм*⁴. Сурвалж судлалын асуудлыг хөндөж буй учраас юуны өмнө “эх сурвалж” гэж юуг ойлгох вэ гэдэг асуулт урган гарна. Ерөнхий утгаар нь авч үзвэл түүхэн эх сурвалж гэдэг нь өнгөрсөн цаг үеийн үйл явдал, үзэгдэл, харилцаа, үзэл санаа, нийгмийн зохион байгуулалт, амьдралын хэв маягийг танин мэдэх боломж олгохуйц биет болон бичмэл баримтыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хүний нийгэмд болж өнгөрсөн үйл явцыг шууд болон дам байдлаар тусгасан бичиг баримт, эд өлгийн зүйлс, архивын материал, тэмдэглэл, зохиол, гэрээ, хууль цаазын эмхэтгэл зэрэг нь эх сурвалжид хамаарна. Эдгээр нь агуулгын хувьд олон төрлийн мэдээлэл тээж байдаг бөгөөд тэдгээрийг зөв унших, зөв тайлбарлах нь судалгааны үр дүнгийн чанарыг тодорхойлж байдаг.

Зарим судлаачид сурвалж судлал нь *бодит ертөнцийг таних онцгой арга*⁵ хэмээн тодорхойлжээ. Сурвалж судлал нь зөвхөн баримт цуглуулах ажил бус, харин бодит түүхэн үзэгдлийг шинжлэх ухааны үндэстэйгээр сэргээн ойлгох арга зам мөн. Энэ утгаараа сурвалж судлалд генетикийн арга буюу үүсэл гарвалын арга, бүтэц-холбооны арга, харьцуулалтын арга, түүхчилсэн арга, агуулгын шинжилгээний арга зэрэг олон төрлийн судалгааны аргыг ашигладаг. Эдгээр аргын

¹ Жамсрангийн Болдбаатар, Данзангийн Лүндээжанцан, *Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал*, (Улаанбаатар: 1997, 2011), Удиртгал хэсгээс үзнэ үү.

² John V. Orth, “Doing Legal history”, *Irish Jurist*, 14 (1), 1979, 114, <http://www.jstor.org/stable/44027942>, (Сүүлд үзсэн: 2026.03.06)..

³ *Мөн тэнд.*

⁴ Ц.Гантулга, З.Лонжид, “Түүхийн сурвалж судлал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”, *Монголын түүхийн сурвалж судлал: өнөөгийн байдал, судалгааны асуудлууд (олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал)*, (Эрхэлсэн Ц. Гантулга), (Улаанбаатар: 2004), 7 дахь тал.

⁵ Данилевский И, Кабанов В. В, Медушевская О. М, Румянцева М. Ф, *Источниковедение*, М: 2000-19 с.

тусламжтайгаар эх сурвалжийн үүсэл, бүтэц, хэрэглээ, түүхэн орчин, утга агуулга, хувьсал өөрчлөлтийг тодруулж болдог. Сурвалжгүйгээр, баримтгүйгээр аливаа шинжлэх ухааны дүгнэлт гаргах боломжгүй тул эрх зүйн түүх судлалын хувьд ч эх сурвалжийн асуудал анхдагч ач холбогдолтой хэвээр байна.

Нэгтгэн үзвэл сурвалж судлал бол өөрийн судлах зүйл, судалгааны аргатай түүхийн шинжлэх ухааны нэг салбар ухаан ажээ. Гэхдээ дан гагц түүхийн шинжлэх ухаанд хамаарна гэх нь бас өрөөсгөл. Аль ч шинжлэх ухаан судлах зүйлтэй, тэрхүү судлах зүйл нь тодорхой эх сурвалж, бусад олон зүйлээс бүрдэнэ. Ийм учраас сурвалж судлалыг хавсарга ухаан хэмээн нэрийддэг. Хавсарга ухаан учраас бусад олон шинжлэх ухаанд хамаатна, жишээлбэл эрх зүйн түүх судлалын хувьд сурвалж судлалын ач холбогдол нь Монголын хууль цаазын түүхэн эх сурвалжуудтай шууд холбогдоно. Өнөөдөр бидэнд мэдэгдэж буй Монголын хууль цаазын эх сурвалжууд тооны хувьд олон биш боловч агуулгын хувьд нэн баялаг юм. Тухайлбал, Их засгийн хууль, Арван буянт номын цагаан түүх, Алтан ханы цааз, Үйсэнд бичсэн цаазууд, 1640 оны Их цааз, Халх журам, Манжийн төрөөс тогтоосон хууль зүйн бичгүүд, Монгол цаазын бичиг, Богд хаант улсын хууль зүйлийн бичгүүд зэрэг нь Монголын эрх зүйн уламжлалыг танин мэдэхэд суурь ач холбогдолтой эх сурвалжууд юм. Эдгээр нь зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны төдийгүй түүх, хэл шинжлэл, улс төр судлал, соёл судлал зэрэг бусад олон шинжлэх ухааны чухал судлагдахуун болж чадна.

Хууль цаазын эх сурвалжийг зөвхөн дан гагц хууль зүйн үүднээс судлан шинжлэх нь учир дутагдалтай. Учир нь эдгээр сурвалжийн агуулж буй мэдээ баримт, үйлдсэн цаг хугацаа, арга технологи, шинж онцлог, түүхэн нөхцөл, судалсан ашигласан байдал, хэм хэмжээний агуулга гэх мэт олон төрлийн судалгааг хийх шаардлага үүснэ.

Нөгөө талаар хууль зүйн судалгааг зөв хийхийн тулд юуны өмнө тухайн эх сурвалжийн эх бичгийн судалгааг зөв хийсэн байхыг шаарддаг. Үүнтэй холбогдон эх бичиг судлалын үүрэг онцгой ач холбогдолтой болж ирнэ. Эх бичгийн судлалд бичгээр үлдсэн бүх зүйл судлагдахуун нь болдог. Эх бичиг судлал нь бичгээр уламжлагдан ирсэн эхийн төрөл, хэлбэр, хувилбар, жинхэнэ болон хуулбар эхийн ялгаа, үсэг бичгийн онцлог, бүтэц, текстийн хувьсал, орчуулга, галиг, хөрвүүлэг, утга агуулгын задлан шинжилгээг хамардаг. Иймээс эрх зүйн түүх судлалын хувьд ямар нэгэн хууль цаазын эх сурвалжийг судлахдаа тухайн баримт нь жинхэнэ эх үү, хуулбар эх үү, хувилбар эх үү, ноорог эх үү, эсхүл хуурамч эх үү гэдгийг нэн тэргүүнд тогтоох шаардлагатай. Үүний дараа тухайн эх сурвалжийн үйлдэгдсэн орон

зай, цаг хугацаа, зохиосон буюу баталсан субъект, хэрэглээний хүрээ, хэл найруулга, нэр томьёо, ойлголтын агуулгыг судлах ёстой.

Ялангуяа хууль цаазын эх сурвалж дахь нэр томьёо, ойлголт, агуулгыг зөв тайлбарлах асуудал нэн чухал. Практикт нэг нэр томьёог судлаач бүр өөр өөрөөр оноон тайлбарлах, орчуулах, хөрвүүлэх, улмаар тухайн тайлбар нь эхийн жинхэнэ агуулга болон түүхэн хэрэглээтэй нийцэхгүй байх тохиолдол цөөнгүй гардаг. Ийм алдаа нь дараагийн судалгаанд давтагдан хэрэглэгдэх эрсдэлтэй. Иймээс хууль цаазын эх сурвалж дахь нэр томьёо, ойлголт, агуулгыг мэргэжлийн түвшинд зөв тодорхойлох, тайлбарлах, орчуулах, хөрвүүлэхэд зөвхөн хууль зүйн мэдлэг бус, түүх, хэл шинжлэл, эх бичиг судлал, сурвалж судлалын мэдлэг зайлшгүй шаардагдана.

Иймээс эрх зүйн түүх судлал, тэр дундаа хууль цаазын эх сурвалжийн судалгаа нь салбар дундын мэдлэгт тулгуурласан, эх сурвалжийн суурь шинжилгээг зайлшгүй шаарддаг, олон түвшний судалгааны талбар юм. Эх сурвалжийн суурь судалгааг зөв хийх нь эрх зүйн түүхийн цаашдын мэргэжлийн шинжилгээний чанар, үнэн зөв байдал, шинжлэх ухааны ач холбогдлыг үндсэндээ тодорхойлно.

3. Хууль цаазын эх сурвалжийн судалгааны үр дүн

Эрх зүйн түүх судлал нь эрх зүйн онол, сургаал, хууль цаазын түүхэн эх сурвалж, баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан тодорхой цаг үед нийгмийн харилцааг хэрхэн зохицуулж байсан, төрийн бодлого ямар агуулгатай байсныг, төрийн байгуулал, байгууламжийн хэлбэр, хэв шинж хэрхэн бүрэлдэн хөгжсөнийг тайлбарлах боломж олгодог. Үүний зэрэгцээ тухайн нийгмийн эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн соёл, зан заншил, ахуй амьдрал, үнэт зүйл, нийгмийн зохион байгуулалтын онцлогийг танин мэдэх өргөн боломжийг бүрдүүлдэг. Энэ утгаараа хууль цаазын эх сурвалжийн судалгаа нь зөвхөн өнгөрсөн үеийн хуулийн бичвэрийг тайлбарлах төдий бус, харин тухайн нийгмийн оюуны болон институтийн түүхийг сэргээн ойлгох чухал гарц болдог.

Өнөөдөр судалгааны түвшинд илэрч судлагдсан монголын хууль цаазын түүхэнд холбогдох эх сурвалж харьцангуй цөөн боловч тэдгээрийг судалгааны эргэлтэд оруулж, задлан шинжилж, нэгтгэн дүгнэсэн бүтээл багагүй бий. Ялангуяа эх сурвалжийн судалгааны чиглэлээр чамлахааргүй хэмжээний бүтээл нийтлэгдсэн нь Монголын эрх зүйн түүх судлалын суурь хөгжил бүрэлдсэнийг харуулж байна.

Монголын уламжлалт хууль цаазын эх сурвалжийг системтэйгээр судалж эхэлсэн түүх XVIII зуунаас эхтэй бөгөөд анхны томоохон алхмыг Европын, ялангуяа Орос, Германы монголч эрдэмтэд хийжээ. Монголын хууль цаазын эх сурвалжуудаас 1640 оны Их цааз хамгийн

түрүүнд эрдэм шинжилгээний эргэлтэд орсон байна. Оросын эрдэмтэн Б.М. Бакунин 1776 онд уг цаазыг “Монгол-Халимагийн хууль цааз” нэрээр орос хэлээр хэвлүүлсэн бол мөн онд Германы эрдэмтэн П.С. Паллас “Монголчуудын хууль цааз” нэрээр герман хэлээр нийтэлжээ. Ийнхүү “Их цааз”-ын судалгааны эхлэл тавигдсан юм⁶.

Хожим Ф.И.Леонтович 1879 онд уг хуулийг дахин хэвлүүлж, эх сурвалжийн гарал үүслийг тодорхойлох анхны оролдлогыг хийсэн⁷ бол К.Ф. Голстунский 1880 онд тод бичгийн эхийг хавсарган, нэмэлтүүдийн хамт орос хэлээр орчуулж, тайлбар бүхий хэвлэл⁸ гаргасан нь энэ чиглэлийн судалгаанд томоохон ахиц авчирсан.

Үүнээс хойш тус цаазыг Оросын эрдэмтэн В.А.Рязановский⁹, С.Д.Дылыков¹⁰, Японы эрдэмтэн Таяама Шигэрү¹¹, Америкийн эрдэмтэн Жон.Р.Крюгер¹², БНХАУ-ын Ло И Пин¹³, Дорнотив¹⁴, Буян-Өлзий, Боу Гэ¹⁵, Ц.Бат¹⁶, Монголын судлагчдаас доктор Т.Алтангэрэл¹⁷, Б.Батбаяр¹⁸ зэрэг дотоод, гадаадын судлаачид тусгайлан¹⁹ судалж, эх бичиг, агуулга, бүтэц, түүхэн ач холбогдлын үүднээс олон талт шинжилгээ хийсэн ажээ.

Үүнчлэн Монголын хууль цаазын бусад чухал эх сурвалжууд болох Арван буянт номын цагаан түүхийг Германы монголч эрдэмтэн В.Хайссиг²⁰, К.Сагастер²¹, Өвөрмонголын эрдэмтэн Лю

⁶ Баянбаатарын Баятбаяр, *Их цаазын эх бичгийн судалгаа*, (Улаанбаатар: 2008), 11 дэх тал.

⁷ Леонтович Ф. И., *К истории права русских инородцев. Древний Монгол-ойратский устав взысканий (цаазын бичиг)*, (Одесса: 1879).

⁸ Голстунского К. Ф., *Монголо-Ойратские законы 1640 года*, (СПб.: 1880).

⁹ Рязановский В. А., *Монгольское право (преимущественно обычное). Исторический очерк*, (Харбин: 1931).

¹⁰ Дылыков С. Д., *Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в.*, (Москва: 1981).

¹¹ Tayaama Sigeru, *Čin ulus-un ūy-e deki mongyolčud-un neyigem-ün bayiyulul, (Buyandelger mongyolčilaba)*, (Kökeqota: 1988), 443-479.

¹² John R. Krueger, “New Materials on Oirat Law and History, Part One: The Jinjil Decrees”, *Central Asiatic Journal*, 16, 1972, 194-205.

¹³ Batu Č., *Mongyol-Oyirad-un čayaja-yin bičig-ün ūge keolge-yin sudulul*, (Begejing: 2006), 23.

¹⁴ *Oyirad čayaja*, (Dorunatib qaričayulun tayilburilaba), (Kökeqota: 1985).

¹⁵ *Mongyol-Oyirad-un čayaja-yin bičig*, (E. Buyanöljei, Bu Ke nar qaričayulun tayilburilaba), (Kökeqota: 2000).

¹⁶ Batu Č., “*Mongyol-Oyirad-un yeke čayaja*”-yin surbulji bičig sudulul, (Begejing: 2016).

¹⁷ Т.Алтангэрэл, *Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь*, (Улаанбаатар: 2001).

¹⁸ Баянбаатарын Батбаяр, *өмнөх эшлэл б.*

¹⁹ Энэхүү илтгэлд эх сурвалжийг хөрвүүлсэн, эмхэтгэсэн бүтээлүүдийг хамруулаагүй болно.

²⁰ Walther Heissig, *Familien-und Kirchengeschichtsschreibung der Mongolen. Teil I*, (Wiesbaden: Otto Harrassowitz, 1959).

²¹ Sagaster K., *Die Weisse Geschichte (Čayan teülke)*, (Wiesbaden: Otto Harrassowitz,

Жинь Со²², Тугч Эрхсэцэн²³, Оросын эрдэмтэн П.Б.Балданжапова, Ц.П.Ванчикова²⁴, Монголын судлагчдаас академич Ш.Нацагдорж²⁵, Б.Баярсайхан²⁶, Ш.Чоймаа, Р.Төрдалай²⁷, Б.Батбаяр²⁸, Алтан ханы цаазыг Германы эрдэмтэн Р.О.Майзецал²⁹, Японы эрдэмтэн Шимада³⁰, Өвөрмонголын эрдэмтэн Чигэ³¹, Сүрэг³², Монголын эрдэмтдээс академич Ш.Бира³³, Б.Баяртуяа³⁴, Б.Батбаяр³⁵, Үйсэн цаазуудыг Х.Пэрлээ³⁶, Фүтаки Хироши³⁷, А.Д.Насилова³⁸, Туяа³⁹, Халх журам цаазыг Цэвээн Жамсранов, Н.А.Турунов⁴⁰, В.А.Рязановский⁴¹, С.Д.Дылыков⁴², Дорнотив⁴³, С.Жалан-Аажав⁴⁴, Ц.Насанбалжир⁴⁵,

1976).

²² Liu Jin Soo, *Arban buyantu nom-un šayan teiike*, (Köke qota: 2001).

²³ Qutuıtai jokiyaba, *Tyüči Erkesečen, Erten-ü boyda qaqad-un bayııuluısan dörben yeke törı-yin arban buyan-tu nom-un šayan teiike*, (Köke qota: 2012).

²⁴ П. Б. Балданжапова, Ц. П. Ванчикова, *Šayan teiike - “Белая история” монгольский историко-правовой памятник XIII-XVI вв.*, (Улан-Үдэ: 2001).

²⁵ Шагдаржавын Нацагдорж, *“Цагаан түүх”-ийн тухай*, (Улаанбаатар: 1956).

²⁶ Батсүхийн Баярсайхан, *Монгол Улсын Арван буянт номын цагаан түүх*, (Улаанбаатар: 2002).

²⁷ Шаравын Чоймаа, Раднаасэдийн Төрдалай (Ред.), *Арван буянт номын цагаан түүх*, (Улаанбаатар: 2006).

²⁸ Шаравын Чоймаа, Баянбаатарын Батбаяр (Ред.), *Арван буянт номын цагаан түүх*, (Улаанбаатар: 2015).

²⁹ Meisezahl R. O, “Die Handschrift in den City of Liverpool Museums (1)”, *Zentralasiatische Studen*, (7), 1973, 221-284 дэх тал.

³⁰ 島田正郎 (Shimada Masao), *Мингийн сүүлч, Чингийн эхний монгол хууль цаазын судалгаа*, (Токио: 1984).

³¹ Ćige. Erten-ü mongyol-un qauli šayaja-yin teiike. Liyoning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a, (Köke qota: 2004).

³² 苏鲁格·阿勒坦汗法典·蒙古学信息·1996年第1期·29-35页·第2期·26-33

³³ Шагдарын Бира, “XVI зууны нэгэн монгол цаазын бичиг”, *ШИА-ийн Мэдээ*, (3), 1975, 34-54 дэх тал.

³⁴ Bayartuyay-a, *Altan qaqan-u šayaja-yin sudulul*, (Köke qota: 2013).

³⁵ Баянбаатарын Батбаяр, Бадамгүрийн Баяртуяа, “Алтан ханы цааз /орчуулга, харьцуулсан судалгаа”, *Эрх зүй*, 35, 2016, 91-146 дахь тал.

³⁶ Хөдөөгийн Пэрлээ, *Монгол ба төв азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг*, (Улаанбаатар: 1974).

³⁷ Futaki Hiroshi, “Үйсэн цаазын тайлбар”, *Mongol Sudulul*, (49), 1976, 10-19 дэх тал.

³⁸ Насилова А. Д, *Восемнадцать степных законов, Памятник монгольского права XVI-XVII вв.*, (Спб.: 2002).

³⁹ Туяа, *Үйсэн цаазын судалгаа*, (Хөххот: 2019).

⁴⁰ Жамцарано Ц. Ж, Турунов А. Н, “Халха джирум – описание памятника”, *Сборник трудов Иркутского университета*, (6), 1923.

⁴¹ Valentin A. Riasanovsky, *Fundamental principles of Mongol Law*, (Indiana: 1965).

⁴² Халха Джирум. *Памятник монгольского феодального права XVIII в.*, (Эрхэлсэн С. Д. Дылыков), (Москва: 1965).

⁴³ *Qalq-a jirum*, (Dorunatib nayııayulun tayilburilaba), (Kökeqota: 1989).

⁴⁴ Сампилин Жалан-Аажав, *Халх журам*, (Улаанбаатар: 1995).

⁴⁵ *Qalq-a jirum*, (Ц. Насанбалжир хэвлэлд бэлтгэсэн), (Улаанбаатар: 1960).

Б.Баярсайхан, Б.Батбаяр⁴⁶, Монгол цаазын бичгийг В.А.Рязановский⁴⁷, Хойшерт Доротеа⁴⁸, С.Д.Дылыков⁴⁹, Б.Баярсайхан⁵⁰, Манжийн төрөөс тогтоосон Хууль зүйлийн бичгүүдийг Б.Баярсайхан, Б.Батбаяр⁵¹, Улаан хацартыг Ш.Нацагдорж⁵², С.Жалан-Аажав⁵³, Б.Баярсайхан, Б.Батбаяр⁵⁴, Жинхэнэ дагаж явах хууль дүрмийг Ж.Урангуа, Б.Баярсайхан⁵⁵, Монгол Улсын хууль зүйлийн бичгийг доктор Б.Содовсүрэн⁵⁶, Б.Батбаяр⁵⁷, Н.Мичидмаа⁵⁸ зэрэг судлаачид тус тус тусгайлан дагнаж судлан хувь нэмэр оруулсан байна.

Монгол хууль цаазын гол эх сурвалж болох Их засгийн хууль нь дэлхий дахинд хамгийн өргөн судлагдсан эх сурвалжийн нэг боловч түүний жинхэнэ эх бичиг өнөөг хүртэл олдоогүй хэвээр байна. Иймээс түүний эх сурвалжийн суурь судалгаа бүрэн утгаараа хийгдээгүй гэж үзэх үндэстэй.

Харин уг хуулийн бүтэц, агуулга, хэм хэмжээний шинжийг бусад дам сурвалж, тэмдэглэл, түүхэн мэдээ, харьцуулсан материалд тулгуурлан сэргээн тодорхойлох оролдлого олон улсын хэмжээнд өргөн хүрээтэй хийгдэж, энэ чиглэл нь бараг бие даасан судалгааны салбар болох хэмжээнд хүрсэн байна⁵⁹.

Судалгааны дүнгээс үзвэл, өнөөдрийн байдлаар биет баримтаар хадгалагдан ирсэн Монголын хууль цаазын эх сурвалжуудаас Арван буянт номын цагаан түүх, Алтан ханы цааз, Үйсэн цаазууд, 1640 оны Их цааз, Халх журам, Монгол цаазын бичиг зэрэгт холбогдох

⁴⁶ Баярсайхан Б, Оюунбилэг Б, Батбаяр Б. *Халх журам (эх бичгийн судалгаа)*. (Улаанбаатар: 2009).

⁴⁷ Ч.Баатар, Н.Лүндэндорж (Орч.), *Рязановский В. А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм*, (Улаанбаатар: 2000).

⁴⁸ Dorothea Heuschert, *Die Gesetzgebung der Qing für die Mongolen*, (Wiesbaden: 1998).

⁴⁹ С. Д. Дылыков, *Цааджин бичиг (Монгольское уложение)*, (Москва: 1998).

⁵⁰ Батсүхийн Баярсайхан, *Монгол цаазын бичигт хийсэн эрх зүйн судалгаа*, (Улаанбаатар: 2005).

⁵¹ Bayarsaiqan B, Batubayar B, *Jarliy-iyar toytagaysan yadayadu mongyol-un törü-yi jasaqi yabudal-un yatin-u qauli jüyil-ün biçig*, (Kökeqota: 2017).

⁵² Шагдаржавын Нацагдорж, *Улаан хацарт*, (Улаанбаатар: 1960).

⁵³ Сампилын Жалан-Аажав, *Улаан хацарт*, (Улаанбаатар: 1996).

⁵⁴ Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ* (Улаан хацарт), (Улаанбаатар: Адмон, 2010).

⁵⁵ Жамсрангийн Урангуа, Батсүхийн Баярсайхан, *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм*, (Улаанбаатар: 2004).

⁵⁶ Бадамын Содовсүрэн, *Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920)*, (Улаанбаатар: 1989).

⁵⁷ Баянбаатарын Батбаяр, *Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг (агуулга, мөн чанар)*, (Улаанбаатар: 2011).

⁵⁸ Mičidm-a, N. *Jarliy-iyar toytagaysan mongyol ulus-un qauli jüil-ün biçig-ün suduly-a. doktor-un čola qamayalaqu ögülel. Tusqai teüke*. (Kökeqota, 2016).

⁵⁹ Баянбаатарын Батбаяр, “Их засаг”-ийн эхийг бүтээх асуудал”, “Их засаг”-ийн эхийг эрэн сурвалжлах нь, (Улаанбаатар: 2015), 85 дахь тал.

суурь судалгаа харьцангуй сайн хийгдсэн гэж үзэж болно. Үүнд түрүү үеийнхээс Б.М.Бакунин, П.С.Паллас, Ф.И.Леонтович, К.Ф.Голстунский, В.А.Рязановский, Цэвээн Жамсранов, Н.А.Турунов, С.Д.Дылыков, В.Хайссиг, К.Сагастер зэрэг дэлхийн нэрт монголч эрдэмтэд хийгээд монголын эрдэмтдээс академич Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Ц.Насанбалжир, Ш.Бира, С.Жалан-Аажав нар жинтэй хувь нэмэр оруулсныг тэдний удаа дараагийн бүтээлүүдээс бэлхнээ харж болохоор байна. Тиймээс тэдгээр судалгаа нь энэ чиглэлийн хөгжлийн үндэс суурийг тавьсан гэж үзэж болно. Харин Манжийн төрөөс тогтоосон хууль зүйлийн бичиг, тодруулбал Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг болон Богд хаант засгийн үеийн Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг зэрэг хууль цаазын томоохон эх сурвалжийн иж бүрэн суурь судалгаа өнөө хэр хангалттай хийгдээгүй байна. Энэ нь Монголын эрх зүйн түүхийн шилжилтийн үеийн эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь ойлгоход томоохон хоосон орон зай үлдээж байна.

Монголын хууль цаазын эх сурвалжийн судалгаанд түрүү үеийн эрдэмтдийг залгаж Таяама Шигэрү, Шимада, Лю Жинь Со, Дорнотив, Сүрэг, Чигэ, Буян-Өлзий, Боу Гэ, Фүтаки Хироши, Хойшерт Доротеа, П.Б.Балданжапова, А.Д.Насилова, сүүлийн үес Б.Баярсайхан, Ц.Бат, Б.Батбаяр, Б.Баяртуяа нарын судлаачид зохих хувь нэмэр оруулсаар ирснийг дурдах нь зүйтэй.

Хууль цаазын эх сурвалжийн судалгааны өнөөгийн байдлыг авч үзвэл анх түрүүн гадаадын монголч нар түлхүү анхаарч ирсэн байх ба дараагаар нь монгол эрдэмтдийн хувь нэмэр зохих байрыг эзэлсээр ирсэн хэдий ч энэ эрч сүүлийн үес саарчээ. Нөгөөтээгүүр энэ чиглэлийн мэргэшсэн судлаач хангалттай бус⁶⁰ зэргээс үүдэж хууль цаазын ховор нандин зарим эх сурвалжууд өдгөө болтол судалгааны эргэлтэд орж, олны хүртээл болж чадахгүй байсаар байна.

Түүнчлэн зарим эх сурвалжийн судалгаа өмнө нь нэг удаа хийгдсэн боловч өнөөдрийн судалгааны шаардлага, шинэ эх баримт, шинэ арга зүйн үүднээс дахин нягтлах шаардлагатай болжээ. Үүнд Алтан ханы цааз, Үйсэн цааз, Монгол цаазын бичиг, Жинхэнэ дагаж явах хууль дүрэм зэрэг эх сурвалжийг онцлон дурдаж болно. Учир нь эдгээрийн заримд тухайлбал орчуулга, хөрвүүлэг, нэр томьёо, агуулгын тайлбар, эх сурвалжийн төрөл, ангилал, он цаг тогтоолт, хэрэглээний хүрээ, баримтын шинж чанартай холбоотой маргаантай асуудал, алдаа, зөрүү, эсхүл үндэслэл сул дүгнэлтүүд ажиглагддаг.

Нэгтгэн дүгнэвэл, Монголын эрх зүйн түүх судлал, тэр дундаа уламжлалт хууль цаазын эх сурвалжийн суурь судалгааны үндэс нэгэнт

⁶⁰ Өдгөө хууль цаазын эх сурвалжаар дагнан судалдаг судлаач нэн цөөн байна.

тавигдаж, тодорхой түвшинд төлөвшин бэхэжсэн гэж үзэж болохоор байна. Харин цаашид энэ суурь дээр тулгуурлан эх сурвалжийн шинэ шүүлт хийх, эх бичгийг дахин нягтлах, орчуулга, хөрвүүлгийг шинэчлэх, нэр томьёоны нэгдмэл байдлыг хангах, улмаар тухайн эх сурвалж дахь хэм хэмжээ, эрх зүйн үзэл санаа, салбар эрх зүйн агуулгыг мэргэжлийн түвшинд нарийвчлан судлах шаардлага нэн өндөр хэвээр байна.

4. Хууль цаазын эх сурвалжийн судалгаанд анхаарах зарим асуудал

Монголын хууль цаазын эх сурвалжийн судалгааны үр дүн, хүрсэн түвшин, өнөөгийн байдлыг авч үзэхэд анхаарал татсан цөөнгүй асуудал бий. Энд тэдгээрээс сэдвийн хүрээнд уялдуулж хоёр асуудлыг жишээ болгон товч хөндье. Хууль цаазын эх сурвалжуудаас Алтан ханы цааз, Үйсэн цааз, Монгол цаазын бичиг, Жинхэнэ дагаж явах хууль дүрэм зэрэг эх сурвалжийг нэхэн судлах шаардлага бийг өмнө дурдсан. Үүнээс Жинхэнэ дагаж явах хууль дүрэм хэмээх нэртэй эрх зүйн эх сурвалжийг түүхийн ухааны доктор Ж.Урангуа, хууль зүйн доктор Б.Баярсайхан нар судалж, эх бичгийн судалгааг нь хийж, 2004 онд нийтлүүлжээ⁶¹. Ийнхүү эх бичгийн судалгааг хийж, оршил хэсэгтээ тухайн эх сурвалжийн тухай болон төрийн байгуулал, зохицуулсан харилцааны шинж, онцлог хийгээд эрүүгийн хэм хэмжээ, ял шийтгэлийн бодлогыг судалж, үнэлэлт дүгнэлт өгчээ. Ингээд галиг, орчуулга, хөрвүүлэг, судалгаа, тайлбар, үгийн хэлхээ зэрэг эх бичгийн судалгаанд байвал зохих судалгаанаас хөрвүүлэг, галиг, үгийн хэлхээг үйлдэж, уг эхийг хавсарган нийтэлсэн байдаг. Ийнхүү тус эх сурвалжийг анх удаа олон нийтийн анхааралд хүргэж, судалгааны эргэлтэд оруулснаараа энэ бүтээл чухал ач холбогдолтой болсон.

Гэвч эх бичгийн судалгаанд зайлшгүй байх ёстой тухайн эх сурвалжийн тухай мэдээлэл, орон зай, цаг хугацаа, газар орон зэргийг тодруулаагүй буюу уг эх сурвалж нь жинхэнэ эх үү, хуулбар юм уу, хаанаас олдсон, хэн зохиосон, эсхүл баталсан, үүнээс өмнө хойно гарсан бусад эх сурвалжтай харьцуулах зэрэг эрдэм шинжилгээний гол гол шаардлага, шалгуурыг хамран судлаагүй, үүнээс үүдэж үндэсгүй дүгнэлтэд хүрсэн зэрэг шүүмжлэлийг дагуулж байна. Тухайлбал, тус бүтээлд *1918 онд уг цаазыг бүрэн хэмжээгээр мөрдсөн гэж үзвэл 1911 оноос хойш 1918 оныг хүртэл Богд хаант Монгол улсын нийгмийн харилцааг хэрхэн, ямар эрх зүйн эх сурвалжаар зохицуулж байсан бол гэсэн сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө*⁶² гээд үүнийхээ хариу болгож

⁶¹ Жамсрангийн Урангуа, Батсүхийн Баярсайхан, *өмнөх зиллэл* 55.

⁶² *Мөн тэнд.* 10 дахь тал

... Богд хаант Монгол улсын Шуух таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны “Олноо өргөгдсөний тэргүүн оноос нааш олон яамнаас айлтгаад тогтоосон ба тусгайлан зарлиг буулгаж нийтээр дагаж буй хэргийн товчоо дэвтэр” хэмээх данс бүртгэлд 1911 оноос 1917 оны 4 сар хүртэлх хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг бүртгэгдэж байжээ. Тэдгээрийн нэг нь 1913-1919 оны хооронд “Таван яам хамт нийлж хувьсган тогтоож айлтгаад, одоогийн дагаж шийтгүүлэн буй хууль дүрмийн дэвтэр бичиг” буюу “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм” хэмээх 12 зүйл бүхий эрх зүйн актыг эмхтгэн мөрдөж байжээ. Өөрөөр хэлбэл “ЗГМУ-ын Хууль зүйлийн бичиг”-ийг хүчин төгөлдөр мөрдөх хүртэлх нийгмийн харилцааг зохицуулахад чиглэсэн эрх зүйн актууд юм...⁶³ хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнийг дахин магадлах шаардага бий. Учир нь энэхүү цаазад буй зарим хэм хэмжээг Богд хаант улсын үед бус, түүнээс өмнө буюу Манжийн төрийн үед батлан дагаж мөрдөж байсныг архивын баримтаас тогтоох боломжтой байна.

Тодруулбал, Монгол Улсын Үндэсний төв архивын Хөмрөг 99, данс 1, хадгаламжийн нэгж 256-д “Хэвт ёсны 2 дугаар он таван сарын гучин” гэсэн огноотой “Хүрээний зэрэг газрын элдэв зүйлийн гажуу суртлыг ариутган цаазалж, шар шашны үндсийг зузаатгах үүнийг эрхэмлэх ёсыг барьж дүрэм хэмжээ тогтоосныг бага сага залруулан засамжилж тогтоон тушаасан бичиг”⁶⁴ хэмээх нэртэй баримт хадгалагдаж буй бөгөөд тус эх бичгийн агуулга Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн 12 дахь зүйл (бүлэг) буюу Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа) бүтээлийн 185-263 дахь талд буй эх бичгийн агуулгатай үг, үсгийн ямар ч зөрүүгүй адилхан байна. Эндээс үзвэл Жинхэнэ дагаж явах хууль дүрэм хэмээх эх сурвалж үнэхээр Богд хаант төрийн үед батлагдсан, тэр үеийн хууль цааз мөн эсэх асуудлыг тодлох шаардлага урган гарч байна.

Түүнчлэн тус эх сурвалжийг судалсан судлаачдын тогтоосноор Жинхэнэ дагаж явах хууль дүрмийг 1913-1919 онд дагаж мөрдөж байжээ⁶⁵. Архивын баримтын огноог харвал хэвт ёсны 2 дугаар он гэж буй, энэ нь нийтийн тооллын 1910 онтой дүйцнэ. Тиймээс он цагийн хүрээг эргэж харах шаардлага үүсэж байна. Эх бичгийн судалгаанд тухайн баримтын эхлэл, төгсгөлийн үг ихээхэн ач холбогдолтой байдаг. Тус баримтын эхлэл үгээс үзвэл тус цаазыг *Хамба номын хан, Дүйнхор хутагт, Эрдэнэ шанзудба, Засаг да лам нараас Их хүрээний 30 аймгийн нэг болох Амдуу нарын аймгийн лам, гэсгүй, мэдээчин*

⁶³ Мөн тэнд. 10 дахь тал

⁶⁴ МУУТА, Х-99, Д-1, Хн-256.

⁶⁵ Жамсрангийн Урангуа, Батсүхийн Баярсайхан, *өмнөх эшлэл 55*, 10 дахь тал.

нарт зориулж тушаасан⁶⁶ болох нь тодорхой байна. Энэ нь уг баримт нийт улсын хэмжээнд үйлчлэх эрх зүйн акт бус, харин тодорхой хүрээний харьяат хүмүүст хандсан шинжтэй байж болохыг харуулж байна. Цаашилбал, энэхүү эхлэл үгэнд мөн тус цаазыг тухайн үед буюу 1910 онд тогтоосон бус, түүнээс өмнө *Түшээт хан, Сэцэн хан, Их шавь гурван газрын тэргүүн хамба нар зөвлөлдөн тогтоосныг бага сага залруулан засамжилж тогтоосон*⁶⁷ тухай өгүүлжээ. Иймээс уг эх сурвалжийг бүрэн хэмжээгээр Богд хаант улсын үед шинээр тогтоосон хууль цааз хэмээн үзэхэд эргэлзээтэй байна.

Мөн, тус Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн бусад зүйл (бүлэг)-ээс хэм хэмжээ тогтоосон дүрэм журам, байгууллага, албан тушаалтны өөр хоорондоо тушаасан, илгээсэн, явуулсан бичиг зэргийг ялган салгаж, аль нь эрх зүйн эх сурвалж болохыг тодлохоос гадна тухайн хэм хэмжээг дагаж мөрдсөн эсэхийг ч тогтоох хэрэгтэй. Жинхэнэ дагаж явах хууль дүрэмд буй агуулгыг харвал хэм хэмжээ тогтоосон дүрэм журмын шинжтэй гурван акт байх бөгөөд бусад нь хэм хэмжээ тогтоосныг дагаж мөрдөхийг тушаасан, яамд хоорондын тодорхой асуудлаар явуулсан илгээсэн нугалбар бичгүүд байна. Хэм хэмжээ тогтоосон актуудын нэг нь хүчин төгөлдөр мөрдөгдсөн бол нэг нь төсөл ноорог байдлаар буюу Дотоод яамнаас боловсруулж, Шүүх яаманд хянуулахаар явуулсан эх, үлдсэн нэг нь өмнө дурдсан Манжийн төрийн үед дагаж мөрдөж байсан эх сурвалж байна. Дээрхээс үзвэл эхлээд хууль цаазын эх сурвалжийн суурь судалгааг зөв хийх, ингэхдээ бусад салбар шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоог зөв ашиглах, үүний дараа сая мэргэжлийн буюу хууль зүйн задлан шинжилгээг хийх нь зүйтэй болохыг харж болохоор байна.

Хоёр дахь анхаарал татах асуудал нь монгол хууль цаазын эх сурвалжийн өвөрмөц дурсгал болох Үйсэн цаазын судалгаатай холбогдоно. Энэ дурсгалыг анх 1970 онд илрүүлж, 1974 онд судалгааны эргэлтэд оруулснаас⁶⁸ хойш өнөөг хүртэл манай улсад улируулан судалсан нь үгүй. Гадаадын хэд хэдэн эрдэмтэд анхаарал хандуулж судалсан⁶⁹ боловч тэдгээр нь эх бичгийн иж бүрэн судалгааны түвшинд хараахан хүрээгүй юм. Харин 2019 оны сүүлээр БНХАУ-д доктор Туяа Үйсэн цаазын судалгааг нийтлүүлсэн⁷⁰ нь сүүлийн үеийн чухал оролдлогын нэг болсон байна.

Хууль цаазын энэхүү хосгүй үнэт⁷¹ дурсгалыг 1992 онд Монгол

⁶⁶ МУУТА, Х-99, Д-1, Хн-256

⁶⁷ *Мөн тэнд.*

⁶⁸ Хөдөөгийн Пэрлээ, *Өмнөх эшлэл 36.*

⁶⁹ Elisabetta Chiodo, *The Mongolian Manuscript on Birch Bark from Harbuhyn balgas*, (Wiesbaden: 2009).

⁷⁰ Туяа, *Өмнөх эшлэл 39.*

⁷¹ Засгийн газрын 1995 оны 241 дүгээр тогтоолоор “Хосгүй үнэт” дурсгалаар

Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс сэргээн засварлуулах хүсэлт гаргаж, үүний дүнд Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газрын хамтын шийдвэрээр Бонны их сургуульд сэргээн засварлах ажлыг төвлөрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Ингээд 20 орчим жилийн дараа буюу 2012 оны 10 сард ХБНГУ-аас Монголын талд хүлээлгэн өгч, улмаар 2018 онд Монголын Үндэсний номын сангаас эрхэлж, *Хар бухын балгасын үйсэн дээрх бичиг*⁷² номыг хэвлүүлснээр тус цаазын уг эхийг судлах өргөн боломж нээгдсэн юм.

Энэхүү цаазыг судалсан эрдэмтдийн судалгааг авч үзвэл цөм академич Х.Пэрлээгийн гараар хуулж сийрүүлсэн эхийг үндэс болгон барьж, ерөнхийдөө түүний судалгааг дагасан нь ажиглагдаж байна. Энэ нь ч зүйн хэрэг байв. Х.Пэрлээ Үйсэн цаазыг анх судалгааны эргэлтэд оруулж, гараар хуулан сийрүүлж, латин галиг үйлдэж, зарим үгийн тайлбарыг хийснээр хууль зүйн болон түүхийн шинжлэх ухаанд үлэмж хувь нэмэр оруулсан билээ. Түүний бүтээлийн үнэ цэнэ өдгөө ч ач холбогдолтой хэвээр байна.

Гэвч орчин үеийн эх бичиг судлалын шаардлагаар авч үзвэл, анхдагч эхийг гол баримт болгох зарчим илүү чухалд тооцогдоно. Энэ үүднээс харахад Х.Пэрлээгийн гараар хуулсан сийрүүлгийг анхдагч эх сурвалжийн оронд шууд хэрэглэхэд болгоомжтой хандах хэрэгтэй. Учир нь түүнд алдаатай уншсан, орхигдуулсан, давтсан хэсэг цөөнгүй байж болзошгүй бөгөөд 2018 онд нийтлэгдсэн эхийн гэрэл зургуудтай тулган үзэхэд энэ асуудал тодорхой хэмжээнд ажиглагдаж байна. Нөгөө талаар 2018 оны хэвлэлд буй гэрэл зургуудыг судалгааны зориулалтаар системтэй, эмх цэгцтэй дараалуулан байрлуулаагүй, мөн хууль цаазын эх сурвалжийг бусад төрлийн түүхэн болон уран зохиолын дурсгалуудтай хольж нэгтгэн нийтэлсэн нь эх бичгийн судалгаанд тодорхой хүндрэл учруулж байна.

Үйсэн цаазыг сэргээх ажлыг ХБНГУ-д хийсэн тухай өмнө өгүүлсэн. Ийнхүү сэргээн засварлаж, эх бичгүүдийг дараалуулахдаа ямар арга зүйгээр хийснийг олж мэдээгүй тул энд тодорхой дурдах боломжгүй байна. Ямар боловч энэхүү сэргээн засварлах ажлыг удирдсан Германы монголч эрдэмтэн К.Сагастер Үйсэн дээр бичсэн бичгүүдийг тодорхой тоогоор дугаарласан байх бөгөөд түүний 001, 002, 004, 0023(a), 0024(b), 0026(b) дугаар нүүр нь Чингис хааны “Их түгэл”-ийн доторх есөн өрлөгийн магтаалын шүлгийн хэсэг ажээ⁷³ хэмээн түүхийн ухааны доктор Э.Жигмэддорж “Халхын үйсэн цааз”

баталжээ.

⁷² *Хар бухын балгасын үйсэн дээрх бичиг, гэрэл зургийн цомог*, (Улаанбаатар: 2018), 15-70 дахь тал.

⁷³ Энхбаярын Жигмэддорж, “Халхын үйсэн цааз дахь Чингисийн есөн өрлөгийн магтаал”, *ЕвроАзийн нүүдлийн аж ахуй*, (Сэндай: 2016), 31 дэх тал.

дахь Чингисийн есөн өрлөгийн магтаал сэдэвт өгүүлэлдээ дурдсан байна. Тэрээр өгүүллийн нэрээ ийнхүү оноосноос гадна өгүүлэлдээ хэд хэдэн удаа *Үйсэн цааз дахь есөн өрлөгийн магтаал, Үйсэн цаазад бичигдсэн зургаан түмний их түгэлийн бичиг* гэх мэтээр онцлон дурдаж, улмаар энэ судалгааны дүнд тодорч буй өөр нэг зүйл нь *Халхын үйсэн цаазын агуулга юм. Бидний үзэхээр Халхын үйсэн цаазын агуулга нь 1-д XVI зууны сүүлчээс (1596) XVII зууны 30-аад он (1639) хүртэл Монголын язгууртан ноёдын арван найман удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон цааз, 2-д Зургаан түмний их түгэлийн бичиг хэмээх Чингис хааны 9 өрлөгийн магтаал хэмээх хоёр хэсгээс бүрдэж байна*⁷⁴ гэж үндэсгүй дүгнэлт хийжээ.

Үйсэн дээрх бичгүүдийг анх олсон Х.Пэрлээ тэдгээрийг сэдэв ухаанаар нь 1) *шашны элдэв судар, 2) Бөө-буддын шашны элдэв заншил хутгалдсан мэргэ төлөг, цээрийн бичиг, сүнсний орших байрыг үзэх бичиг, ганзаганы сан, 3) хууль цаазны хураамж бичиг, 4) монголын уйгаржин бичгийн цагаан толгой үсэглэл зэрэг болно*⁷⁵ хэмээн ангилан тодорхойлсон байдаг. Энэ мэт үйсэн дээр бичсэн ном бичгийн дурсгалууд цөөнгүй бөгөөд дээр дурдсан Зургаан түмний их түгэлийн бичиг нь тусдаа бие даасан өөр дурсгал, эх бичиг болохоос бус Үйсэн цаазын дотор бичсэн, тэр дундаа Үйсэн цаазын агуулгын нэг байж таарахгүй нь тодорхой. Иймд түүнийг Үйсэн цаазын агуулгын бүрэлдэхүүн хэсэг болгон үзэх нь шинжлэх ухааны хувьд үндэслэлгүй юм. Эндээс үзвэл Үйсэн цаазын эх сурвалжийн цогц судалгааг шинээр хийх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна. Түүнчлэн судлагдсан эх сурвалжуудаа дахин нягтлахаас гадна өнөөг хүртэл судалгааны эргэлтэд бүрэн ороогүй хууль цаазын бусад дурсгалыг эрэн сурвалжилж, илрүүлэн, шинжлэх ухааны эргэлтэд оруулах нь чухал хэвээр байна.

5. Эрх зүйн түүх судлалын чиг хандлага ба цаашдын зорилго

Монгол Улс дэлхий хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхахын хэрээр хууль зүйн шинжлэх ухааны үүрэг, ач холбогдол урьд өмнөхөөс улам өсөн нэмэгдэж байна. Үүнтэй уялдан эрх зүйн төрөл бүрийн судалгаа өргөжиж, судалгааны шинэ чиглэл, арга зүйн янз бүрийн хандлага, үзэл баримтлал бий болсоор байгаа бөгөөд энэ үйл явц өдгөө ч үргэлжилсээр байна.

Монголын хууль цаазын эх сурвалжийг анх XVIII зууны үеэс гадаадын монголч эрдэмтэд анхааран судалж эхэлсэн бол Монгол Улсад тэдгээрийг эрэн сурвалжлах, цуглуулах, сан хөмрөг бүрдүүлэх,

⁷⁴ Мөн тэнд. 39 дэх тал

⁷⁵ Хөдөөгийн Пэрлээ, *өмнөх эшлэл 36*, 6 дахь тал.

судлан шинжлэх ажил XX зууны эхэн үеэс эрчимжжээ. Улмаар XX зууны 60, 70-аад оноос энэ чиглэлийн судалгаа илүү системтэй болж, 80-90-ээд он гэхэд тодорхой хэмжээнд төлөвшин бэхэжсэн бөгөөд XXI зуун гарсаар хөгжлийн шинэ шатанд дэвшин орсон гэж үзэж болно.

Өмнө дурдсан судалгаанаас үзвэл монгол хуулийн талаар гарсан судалгааны бүтээлийн үлэмжхэн хэсэг нь хууль цаазын сурвалж судлалд холбогдож байна. Энэ хүрээнд гарсан бүтээл туурвилуудын судалгааны арга зүй чамбайран боловсорч, түүх, сурвалж судлал, эх бичгийн судалгааны онол, арга зүйг ашиглан, улам бүр цогц судалгаа хийхийг эрмэлзсээр ирсэн нь ажиглагдаж буй. Гэвч анхаарал татсан асуудал төдий олон, цаашид нэхэн магадлах, засаж залруулах, шинжлэн судлах ажил тэр хэрээр байх бөгөөд энэ нь угаас нийгмийн шинжлэх ухааны өөрийн нь мөн чанар билээ.

Хууль цаазын эх сурвалжийн хэм хэмжээний агуулга, эсхүл тодорхой институт, эрх зүйн хүрээгээр тусгайлан хийсэн судалгаа нэн цөөн, судлах хэрэгцээ, шаардлага байгааг өмнө цухас дурдсан. Энэ хэсэгт түүнийг багахан дэлгэрүүлж авч үзье.

Нэгдүгээрт, Монголын уламжлалт хууль цаазын судалгааны үр дүнг арга зүйн хувьд ерөнхийд нь 1) эх сурвалжийн судалгаа, 2) эрх зүйн судалгаа гэж 2 ангилан авч үзэх нь зүйтэй. Өгүүллийн өмнөх хэсэгт их төлөв хууль цаазын эх сурвалжийн судалгааг хөндсөн. Ингэхдээ бусад салбарын, ялангуяа сурвалж судлал, эх бичиг судлал зэрэг түүх, хэлний шинжлэлийн ухааныг зохистой хослуулан хэрэглэх нь тухайн судалгааны үр дүнг илүү чанартай, алдаа мадаг багатай, шинжлэх ухааны үндэстэй, ач холбогдолтой болохыг тодруулсан. Тэгвэл эрх зүйн судалгаа буюу монголын хууль цаазын эх сурвалж, түүнд буй хэм хэмжээ, агуулгыг хууль зүйн үүднээс түүхчлэн судлах нь, эдүгээчлэн судлах нь нэн ач холбогдолтой, зайлшгүй анхаарвал зохих чухал асуудал мөн. Энэ чиглэлээр 1995 онд Монгол хууль цааз дахь заншлын ба эрх зүйн хэм хэмжээний харьцаа сэдвээр Г.Баярхүү, 2000 онд Монгол-Ойрадын их цааз, түүний эрх зүйн судалгаа сэдвээр Т.Алтангэрэл, 2004 онд Монгол цаазын бичигт хийсэн эрх зүйн судалгаа сэдвээр Б.Баярсайхан, 2009 онд Монголын эрх зүй дэх жишгийн эрх зүй сэдвээр Б.Гүнбилэг нар докторын зэрэг хамгаалжээ. Гэвч эдгээрийг нийт хууль зүйн салбарын докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийн судалгаатай харьцуулахад тоо, хамрах хүрээний хувьд нэн бага хэвээр байна.

Хоёрдугаарт, эрх зүйн түүхийн судалгааг 1) ерөнхий болон 2) тусгай гэсэн хоёр түвшинд авч үзэж болно. Ерөнхий түвшинд

профессор И.Дашнямын эрх зүйн түүхийн 2 боть суурь бүтээлийг⁷⁶ дурдах хэрэгтэй. Тус бүтээлд Монголын эрх зүйн түүхийн эрт үеэс XIV зууныг хүртэлхийг бүхэлд нь хамарч нэгтгэн дүгнэсэн, шинжлэх ухааны ач холбогдолтой бүтээл болсон. Үүнээс гадна тодорхой нэг үеийн эрх зүйн түүхийг тусгайлан судалсан зарим бүтээл нь⁷⁷ энэ хэсэгт хамаарч буй. Мөн академич Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлалыг товчоолон судалсан⁷⁸ бүтээлийг дурдаж болно. Харин тусгай буюу эрх зүйн тодорхой салбараар, тодруулбал профессор Т.Мөнхжаргал Монголын иргэний эрх зүйн түүхийг бүхэлд нь авч үзэн судалсан⁷⁹ нь цаашид энэ чиглэлийн судалгаа хийх өргөн боломж буйг харуулав. Энэ жишгээр Монгол Улсын эрүүгийн⁸⁰ болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн⁸¹ түүхэн уламжлалыг тодорхой хугацаа (1911-2009)-ны хүрээнд товчхон тодруулж, холбогдох хууль тогтоомжийг эмхэтгэн хавсаргасан хоёр ч бүтээл нийтлэгдсэн билээ. Үүнээс хойш эрх зүйн аль нэг салбарын чиглэлээр гүнзгийрүүлж, эрх зүйн түүхийн асуудлыг тодруулж, үнэлэлт дүгнэлт өгсөн бүтээл төдийлөн гараагүй байна.

Гуравдугаарт, Эрх зүй, төрийн онол, эрх зүйн философи, харьцуулсан эрх зүй зэрэг хууль зүйн суурь шинжлэх ухааны хүрээнд хийгдсэн судалгаанууд эрх зүйн түүхийн судалгаанд онцгой ач холбогдолтой. Тухайлбал, академич С.Нарангэрэлийн Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо⁸², профессор Х.Сэлэнгийн XIII зууны үеийн монголын төр, эрх зүйн үзэл санаа⁸³, профессор Н.Лүндэндоржийн Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага⁸⁴, доктор Б.Батбаярын Монгол Улсын Хууль зүйлийн бичиг Монголын анхны төрөлжүүлсэн (кодификац) хууль болох нь⁸⁵ зэрэг

⁷⁶ Ишийн Дашням, *Монгол Улсын төр, эрх зүйн түүх*, (Улаанбаатар: 2005, 2011).

⁷⁷ Ишийн Дашням, *Хүннү гүрний төр, эрх зүйн түүх*, (Улаанбаатар: 2017).

⁷⁸ Жамсрангийн Болдбаатар, Данзангийн Лүндээжанцан, *Өмнөх эшилэл I*.

⁷⁹ Тэгшийн Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний цаазын товчоон*. (Улаанбаатар: 2006, 2017).

⁸⁰ Батсүхийн Баярсайхан, Суурийн Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), (Улаанбаатар: 2011).

⁸¹ Батсүхийн Баярсайхан, Дашням Ч, Батжаргал Д. нарын хамт, *Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал*, (Улаанбаатар: 2012).

⁸² Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо (Харьцуулсан эрх зүй)*, (Улаанбаатар: 2001)

⁸³ Хаянхярваагийн Сэлэнгэ, *XIII зууны үеийн монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл*, (Улаанбаатар: 2003).

⁸⁴ Нанзаддоржийн Лүндэндорж, *Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага* (Улаанбаатар: 2002).

⁸⁵ Баянбаатарын Батбаяр, *Монгол Улсын Хууль зүйлийн бичиг Монголын анхны*

бүтээлд эрх зүйн түүхийн чухал асуудлуудыг хөндөн авч үзсэн байдаг. Гэвч эдгээр суурь чиглэлийн судалгаа нь бусад салбар эрх зүйтэй харьцуулахад тоо, нөлөөллийн хувьд хангалтгүй хэвээр байна.

Дөрөвдүгээрт, хууль зүйн ухаанаар хамгаалсан докторын диссертац, магистрын судалгааны ажил, бусад салбар эрх зүйн нэг сэдэвт бүтээл, ном, сурах бичиг, гарын авлага зэрэгт тухайн судлагдахууны түүхийн асуудлыг товч хөндөн судалсан зүйл их байх боловч тэдгээр нь гол төлөв “өмнө нь ийм байсан, дараа нь ийм болсон” гэсэн танин мэдэхүйн шинжтэй, тайлбар төдий байх нь элбэг. Эрх зүйн түүхийн судалгааны нэг гол чиг үүрэг бол тухайн үзэгдэл, харилцааны хөгжлийн динамикийг тодорхойлохоос гадна өмнө ямар байгаад, одоо яагаад ийм болсон зэрэг шалтгаан учрыг тодруулж, цаашид ямар байх, яах ёстой юм бэ гэдэг үндэслэл, саналыг тодорхойлох явдал бөгөөд тэгж байж сая тэрхүү судалгааны хүрээнд судлагдсаны шинжлэх ухааны ач холбогдол нь илэрдэг билээ.

Тавдугаарт, судлаачийн хийсэн түүвэр судалгаанаас үзвэл⁸⁶ хууль зүйн ухаанаар нийтлэгдсэн судалгааны бүтээлүүдийн дотор хамгийн их хувийг эрүүгийн эрх зүйн салбар эзэлж буй бол эрх зүй, төрийн онол, түүх, эрх зүйн философи болон олон улсын эрх зүйн салбарынх хамгийн бага хувийг эзэлж байна. Үүнд тухай тухайн салбарын судлаачид зохих анхаарал хандуулах нь бас их чухал юм. Тэрчлэн яагаад ийм болов гэдгийг эргэцүүлэн тунгааж, хэлэлцэх нь цаашид хэрхэх вэ гэдэг арга замыг эрэлхийлэхэд тус болж юуны магад. Миний үзэж буйгаар, нэг талаар шинжлэх ухааны академик судалгаа гэхээс илүүтэй өнөөгийн практик хэрэглээг нэн тэргүүнд тавьж, гадаадын туршлагыг голлон дагах хандлага нөлөөлж байгаа бол нөгөө талаар үндэсний эрх зүйн уламжлал, үзэл санаа, сэтгэлгээ, эрх зүйн соёлын түүхэн суурийг хангалттай үнэлэхгүй явж ирсэн сэтгэлгээ бас нөлөөлж байж болох юм.

төрөлжүүлсэн (кодификац) хууль болох нь, Хууль зүйн ухааны докторын зэрэг горлисон диссертац, (Улаанбаатар: 2025)

⁸⁶ *Хууль зүйн шинжлэх ухааны бүтээлийн нэгдсэн бүртгэл: 1911-2022* (ноорог). Зохиогчийн хувийн архиваас. Тайлбарлах нь: Зохиогч нь судлаач А.Түвшинтулгын хамт 2012 онд Монгол Улс дахь хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэлийг үйлдэж, 2014 онд хэвлүүлсэн бөгөөд үүнээс хойш нэмж бүртгэсээр өдгөө 2022 оныг дуустал хугацаанд гарсан бүтээлүүдийн их зонхийг бүртгэн төгссөн билээ. Үүний хүрээнд ерөнхий байдлаар эрх зүйн салбараар нь, жишээлбэл Төр, эрх зүйн онол-түүхийн ерөнхий аспектаар болон Үндсэн хуулийн эрх зүй (Үндсэн хуулийн процессын эрх зүй), Захиргааны эрх зүй (Захиргааны процессын эрх зүй, Захиргааны эрх зүйн бусад дэд салбар), Эрүүгийн эрх зүй (Эрүүгийн процессын эрх зүй, Эрүүгийн эрх зүйн холбогдох бусад салбар, чиглэл), Иргэний эрх зүй (Иргэний процессын эрх зүй, Иргэний эрх зүйн бусад дэд салбар), Олон улсын эрх зүй (Олон улсын нийтийн, хувийн эрх зүй), ... Салбар дундын ... гэх мэтээр ангилж бүртгэсэн болно.

Дээр дурдсаныг хураангуйлан авч үзвэл эрх зүйн түүх судлалын чиг хандлага нийгмийн хөгжлийн шаардлага хийгээд тухайн судлаачийн сонирхол, судлагдахууны хэрэгцээнд үндэслэж зохих түвшинд судлагдаж, төлөвшиж тогтсон, тэр хэрээрээ нарийвчилсан, гүнзгийрүүлсэн судалгааг цаашид хөгжүүлэх үндэс суурь бүрдсэн гэж дүгнэж болохоор байна. Судалгааны дээрх үр дүн нь төр, эрх зүйн аливаа үзэгдлийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг таамаглах онол, арга зүйн үндэс болох төдийгүй шинжлэх ухааны чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Нөгөөтээгүүр эрх зүйн түүх судлалын үр дүн нь монголын хууль зүйн шинжлэх ухааны аливаа судлагдахууны шинэ чиглэлийг нээн хөгжүүлэх хөрс суурь болох учиртай. Учир нь өдгөө түүхийг урьд өмнө ийм байсан гэж үздэг тогтсон хандлага алгуур боловч өөрчлөгдөж байна.

Хэдий ийм ололттой тал байх боловч эрх зүйн түүх судлалаар судалгаа хийдэг эрдэмтэн, энэ чиглэлээр нийтлэгдсэн нэг сэдэвт бүтээл болон эрх зүйн тодорхой салбараар гүнзгийрүүлж судалсан судалгааны бүтээл бусад эрх зүйн салбартай харьцуулахад нэн цөөн, мөн тухайн судлагдахууныхаа хүрээнд товч төдий судалсан зүйл байгаа боловч тэр нь задлан шинжилж, үнэлэлт дүгнэлт хийсэн нь бага, ихэвчлэн тоочсон шинжтэй, Монгол Улсад нийтлэгдсэн хууль зүйн судалгааны бүтээлүүдтэй харьцуулахад энэ чиглэлийн судалгаа бага байгаа зэрэг нь асуудлыг эргэн харах, үнэлж цэгнэх, цаашдын зорилгыг тодорхойлохыг зүй ёсоор нөхцөлдүүлж байна.

Дээр дурдсан судалгааны үр дүн, өнөөгийн төлөв, хандлага, тулгамдсан асуудлыг тодорхойлсны дүнд шийдэл нэхсэн асуудлын хүрээнд Монголын эрх зүйн түүх судлалыг цаашид дараах чиглэлээр хөгжүүлэх шаардлагатай байна.

1) Их сургууль, шинжлэх ухааны байгууллага, архив, номын сан, музей болон эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргаж, Монголын уламжлалт хууль цаазын эх сурвалжийн цогц, хамтарсан суурь судалгааны томоохон төсөл хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд түүх, хэл шинжлэл, эх бичиг судлал, сурвалж судлал, хууль зүйн зэрэг олон салбарын судлаачдын оролцоо зайлшгүй хэрэгтэй.

2) Эх сурвалжийн суурь судалгаанд тулгуурлан Монголын эрх зүйн тодорхой салбаруудын түүхийг орчин үеийн онол, арга зүйн шаардлагад нийцүүлэн системтэй судлах шаардлагатай байна. Тухайлбал, Үндсэн хуулийн, захиргааны, эрүүгийн, иргэний гэх мэт салбар эрх зүйн суурь чиглэлүүдээр нэг сэдэвт, гүнзгийрүүлсэн бүтээл туурвих нь зүйтэй.

3) Зөвхөн салбар эрх зүйгээр хязгаарлахгүйгээр, тухайн салбарын

доторх тодорхой институт, элемент, эрх зүйн ойлголт, нэр томьёо, үзэл санаа, эрх зүйн соёл, эрх зүйн ухамсар зэргийг түүхэн хөгжлийн хүрээнд задлан шинжлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эрх зүйн түүхийг зөвхөн хууль тогтоомжийн он дарааллаар бус, харин эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн үнэт зүйлсийн хувьсал өөрчлөлттэй холбон судлах нь чухал юм.

4) Эрх зүйн түүх судлалын үр дүнг практикт хэрэглэх асуудалд мөн анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл, түүхэн судалгааны үр дүн нь зөвхөн танин мэдэхүйн ач холбогдолтой байхаас гадна өнөөгийн хууль тогтоомжийн бодлого боловсруулах, эрх зүйн шинэчлэл хийх, нэр томьёоны нэг мөр ойлголт бүрдүүлэх, эрх зүйн боловсролын агуулгыг баяжуулах, үндэсний онцлогт нийцсэн эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зэрэгт бодитой хувь нэмэр оруулах ёстой.

5) Магистрантур, докторантурын түвшний сургалтад Хэрэглээний эрх зүйн түүх чиглэлийн хичээл, семинар, арга зүйн сургалтыг тусгах нь зүйтэй. Ингэснээр залуу судлаачид тухайн судлагдахууны түүхэн асуудлыг ямар тохиолдолд авч үзэх шаардлагатай, хэрэв авч үзвэл ямар арга зүй, эх сурвалжид тулгуурлах ёстой, тэр судалгааны үр дүнг өнөөгийн практикт хэрхэн холбож хэрэглэх боломжтойг илүү тодорхой ойлгох нөхцөл бүрдэх юм.

Эцэст нь хэлэхэд, хууль зүйн шинжлэх ухааны суурь судлагдахуун болох төр, эрх зүйн онол-түүхийн асуудал нь өнгөрсөнд ч, өнөөдөр ч, цаашид ч тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байх нь дамжиггүй. Харин түүнийг хэрхэн шинэчлэн хөгжүүлэх, хэрхэн үр өгөөжтэй ашиглах, өнөөгийн эрх зүйн бодлого, практикт хэрхэн холбож хэрэглэх тухай асуудал өнөөдөр биднээс хариулт хүлээж байна. Эргэж харахгүйгээр хөгжих боломжгүй гэдэг. Иймээс Монголын эрх зүйн түүхийг үндэсний эрх зүйн ухамсар, сэтгэлгээнд тулгуурлан шинээр бүтээж, гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь чухал байна.

[Ном зүй]

- Batu Ć. “Mongyol-Oyirad-un ĉaġaja-yin biĉig”-ūn kele sudulul. ūndūsūten-ū keblel-ūn qoriy-a, Begejing., 2012
- Batu Ć. “Mongyol-Oyirad-un yeke ĉaġaja”-yin surbulji biĉig sudulul. ūndūsūten-ū keblel-ūn qoriy-a, Begejing., 2016
- Batu Ć. Mongyol-Oyirad-un ĉaġaja-yin biĉig-ūn ūge kelelge-yin sudulul. ūndūsūten-ū keblel-ūn qoriy-a, Begejing., 2006.
- Batubayar, 1640 on-u “Yeke ĉaġaja”, öbŭrmongyol-un suryan kŭmŭjil-ūn keblel-ūn qoriy-a, Kōkeqota., 2017
- Bayarsaiqan Ba, Batubayar Ba. Jarliy-iyar toytaġaysan ġadaġadu mongyol-un törŭ-yi jasaqu yabudal-un yamun-u daġaju yabuylqu qauli jŭyil-ūn biĉig, öbŭrmongyol-un suryan kŭmŭjil-ūn keblel-ūn qoriy-a, Kōkeqota., 2017
- Bayarsaiqan Ba, Batubayar Ba. Qalq-a jirum, öbŭrmongyol-un suryan kŭmŭjil-ūn keblel-ūn qoriy-a, Kōkeqota., 2016
- Bayarsaiqan Ba, Batubayar Ba. Ulaġan qaĉartu, öbŭrmongyol-un suryan kŭmŭjil-ūn keblel-ūn qoriy-a, Kōkeqota., 2016
- Bayartuyay-a. Altan qaġan-u ĉaġaja-yin sudulul. Doctor-un jerge qamaġalaqu öġülel. Kōke qota., 2013
- Ćige. Erten-ū mongyol-un qauli ĉaġaja-yin teŭke. Liyoning-un ūndūsūten-ū keblel-ūn qoriy-a, 2004
- Liu Jin Soo. Arban buyantu nom-un ĉaġan teŭke. öbŭr mongyol-un arad-un keblel-ūn qoriy-a, Kōke qota., 1981
- Liu Jin Soo. Arban buyantu nom-un ĉaġan teŭke. öbŭr mongyol-un arad-un keblel-ūn qoriy-a, Kōke qota., 2001
- Miĉidm-a, N. Jarliy-iyar toytaġaysan mongyol ulus-un qauli jŭil-ūn biĉig-ūn suduly-a. doktor-un ĉola qamaġalaqu öġülel. Tusqai teŭke. Kōkeqota, 2016
- Oyirad ĉaġaja. Dorunatib qariĉaġulun tayilburilaba. Kōkeqota., 1985
- Qalq-a jirum, Ć.Nasunbaljir keblel-dŭ beledkebe. Monumenta Historica Instituti historiae Academiae scientiarum reipublicae populi mongoli, Tomus II, Fasciculus 1. Ulaġanbayatur., 1960
- Qalq-a jirum. Dorunatib nayiraġulun tayilburilaba. Kōkeqota., 1989
- Qutuġtai jokiyaba, Tuġĉi Erkeseĉen oduki kelen-dŭ baġulyaba. Erten-ū boġda qaġad-un baġiyuluġsan dörben yeke törŭ-yin arban buyan-tu nom-un ĉaġan teŭke. öbŭr mongyol-un soyul-un keblel-ūn qoriy-a, Kōke qota., 2012
- Tayama Sigerŭ. Ćin ulus-un ūy-e deki mongyolĉud-un neyigem-ūn baġiyulul. Buyandelger mongyolĉilaba. Kōkeqota., 1988
- Mongyol-Oyirad-un ĉaġaja-yin biĉig. E.Buyanöljei, Bu Ke nar qariĉaġulun tayilburilaba. Kōkeqota., 2000
- Mongyol ĉaġajin-u biĉig (эх бичгийн судалгаа). Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа судалгаа хийсэн Б.Баярсайхан. УБ., 2004
- Алтангэрэл Т. Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж

болох нь. Уб., 2001

Арван буянт номын цагаан түүх. Монгол бичгээс хөрвүүлж, бусад эхтэй харгуулан, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Р.Төрдалай. Уб., 2006

Арван буянт номын цагаан түүх. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, бусад эхтэй харгуулан, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Б.Батбаяр. Уб., 2015

Батбаяр Б, Баяртуяа Б. Алтан ханы цааз /орчуулга, харьцуулсан судалгаа/, - ЭРХ ЗҮЙ / NUM LAW REVIEW, [МУИС-Хууль зүйн сургууль], 2016, №3 (35)

Батбаяр Б. “Их засаг”-ийн эхийг бүтээх асуудал. “Их засаг”-ийн эхийг эрэн сурвалжлах нь – Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2015

Батбаяр Б. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг (агуулга, мөн чанар). Уб., 2011

Батбаяр Б. Их цаазын эх бичгийн судалгаа. Уб., 2008

Баярсайхан Б, Батбаяр Б, Лхагважав Б. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт), Уб., 2010

Баярсайхан Б, Дашням Ч, Батжаргал Д, Энхнасан Ж, Оюунболд Г, Сумьяацэрэн Д. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). Уб., 2012

Баярсайхан Б, Жанцан С, Энхнасан Ж, Сумьяацэрэн Д. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). Уб., 2011

Баярсайхан Б, Оюунбилэг Б, Батбаяр Б. Халх журам (эх бичгийн судалгаа). Дээд, доод дэвтэр. Улаанбаатар, 2009

Баярсайхан Б. Монгол Улсын Арван буянт номын цагаан түүх. Уб., 2002

Баярсайхан Б. Монгол цаазын бичигт хийсэн эрх зүйн судалгаа. Уб., 2005

Бира Ш. XVI зууны нэгэн монгол цаазын бичиг, “ШУА-ийн Мэдээ (нийгмийн ухаан)”, №3, Уб., 1975

Бира Ш. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд, Уб., 1977

Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997

Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж зассан 2 дахь хэвлэл. Уб., 2011

Гантулга Ц, Лонжид З. Түүхийн сурвалж судлал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд. Монголын түүхийн сурвалж судлал: өнөөгийн байдал, судалгааны асуудлууд (олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал). Эрхэлсэн Ц.Гантулга. Уб., 2004

Дашням И. Монгол Улсын төр, эрх зүйн түүх (дэлхийн дорно, өрнө дахинд байгуулагдсан монголын хаант улсуудын төр эрх зүйн түүх). Дэд боть. Уб., 2011

Дашням И. Монгол Улсын төр, эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе). Тэргүүн боть. Уб., 2005

Дашням И. Монголын Юань гүрний төр, эрх зүйн түүх. Уб., 2017

Дашням И. Хүннү гүрний төр, эрх зүйн түүх. Уб., 2011

- Дашням И. Хүннү гүрний төр, эрх зүйн түүх. Уб., 2017
- Жалан-Аажав С. Халх журам бол монголын эртний хууль цаазын дурсгалт бичиг мөн. Уб., 1958
- Жалан-Аажав С. Халх журам. Уб., 1995
- Жигмэддорж Э. “Халхын үйсэн цааз” дахь Чингисийн есөн өрлөгийн магтаал. ЕвроАзийн нүүдлийн аж ахуй: Түүх, Соёл, Хүрээлэх орчин. МУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, БНХАУ-ын ӨМБИС-ийн Аялал жуулчлалын дээд сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Умардын цөөн тоот ард түмний асуудал ба хүмүүнлэгийн судалгааны хүрээлэн, Японы Тохокү их сургуулийн Зүүн хойт Ази судлалын төв хамтран зохион байгуулсан Эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар хот, 2014.09.05. Тохокү их сургууль, Зүүн хойт Ази судлалын төв. Сэндай., 2016
- Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага (ерөнхий болон тусгай онолын асуудлууд). Уб., 2002
- Мөнхжаргал Т. Монгол Улсын Иргэний цаазын товчоон. Уб., 2006;
- Мөнхжаргал Т. Монгол Улсын Иргэний цаазын товчоон. Уб., 2017
- Нацагдорж Ш. “Цагаан түүх”-ийн тухай. Уб., 1956
- Пэрлээ Х. Монгол ба төв азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. Уб., 1974
- Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль. Орчуулсан Ч.Баатар, Н.Лүндэндорж. Уб., 2000
- Содовсүрэн Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). Уб., 1989
- Сэлэнгэ Х. XIII зууны үеийн монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. Уб., 2003
- Улаан хацарт. Оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн С.Жалан-Аажав. Уб., 1996
- Урангуа Ж, Баярсайхан Б. Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа). Уб., 2004
- Хар бухын балгасын үйсэн дээрх бичиг, гэрэл зургийн цомог. Санаачлан хэрэгжүүлэгч МУҮНС. Уб., 2018
- Ѕаяан тейке - “Белая история” монгольский историко-правовой памятник XIII-XVI вв. Составление критического текста и перевод “Белой истории” П.Б.Балданжапова, исследование, редактирование перевода, составление комментариев, подготовка текста “Белой истории” к публикации, перевод и комментарий к “Шастре хана-чакравартина” и “Шастре Орунга” Ц.П. Ванчиковой. Улан-Үдэ., 2001
- Восемнадцать степных законов, Памятник монгольского права XVI-XVII вв. Монгольский текст, транслитерация монгольского текста. Перевод с монгольского, комментарии и исследование А.Д.Насилоа. Спб., 2002
- Голстунскаго К.Ө. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыков при калмыцком хань Дондукь-Даши”. Калмыцкий текстъ съ

- русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880
- Данилевский И, Кабанов В.В, Медушевская О.М, Румянцева М.Ф. Источниковедение. М., 2000
- Дылыков С.Д. “Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в. Ойратский текст. Транслитерация сводного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарий. М., 1981
- Жамцарано Ц.Ж, Турунов А.Н. Халха джирум – описание памятника, - “Сборник трудов Государственного Иркутского университета”, вып. 6, Иркутск., 1923; Qalq-a Jirum. Traduit en russe par Dr. ZAMCARANO. *Studia Mongolica. Instituti Linguae et Litterarum Comiteti Scientiarum et Educationis Altae Republicae Populi Mongoli. Tomus I, Fasciculus I*, Уб., 1959
- Леонтович Ф.И. К истории права русских инородцев. Древний Монгол-ойратский устав взысканий (цаазны бичиг). Одесса 1879
- Нацокдоржи Ш. Улаан хацарт (Описание памятника). Уб., 1956; Улаан хацарт. Хэвлэлд бэлтгэж оршил бичсэн Ш.Нацагдорж. Уб., 1960
- Рязановский В.А. Монгольское право (преимущественно обычное). Исторический очерк. Харбин., 1931
- Халха Джирум. Памятник монгольского феодального права XVIII в. Сводный текст и перевод Ц.Ж.Жамцарано, подготовка текста к изданию, редакция перевода, введение и примечания С.Д.Дылыкова. М., 1965
- Цааджин бичиг (Монгольское уложение). Цинское законодательство для монголов. 1627-1694 гг. Введение, монгольский текст, транслитерация монгольского текста, перевод и комментарии С.Д.Дылыкова. М., 1998
- Elisabetta Chiodo. The Mongolian Manuscript on Birch Bark from Harbuhyn balgas in the Collection of the Mongolian academy of Sciences. Part I, II, *Asiatische Forschungen*, Wiesbaden 2000, 2009
- Fundamental principles of Mongol Law, By Valentin A.Riasanovsky, Indiana., 1965
- Heuschert, Dorothea: Die Gesetzgebung der Qing für die Mongolen im 17. Jahrhundert anhand des Mongolischen Gesetzbuches aus der Kangxi-Zeit (1662-1722) Wiesbaden., 1998
- John R.Krueger. New Materials on Oirat Law and History, Part One: The Jinjil Decrees, - *Central Asiatic Journal*, Volume XVI, Wiesbaden, 1972.
- John V.Orth. Doing Legal history. *Irish Jurist*, New series, Vol. 14, No. 1 (SUMMER 1979)
- Meisezahl. R.O. Die Handschrift in den City of Liverpool Museums (1), *Zentralasiatische Studien*, 1973, №7
- Sagaster K. Die Weisse Geschichte (Čayan teüke). Eine mongolische Quelle zur von den Beiden Ordnungen Religion und Staat in Tibet und der Mongolei. *Asiatische Forschungen*, Band 41. Otto Harrassowitz, Wiesbaden., 1976
- Walther Heissig. Familien-und Kirchengeschichtsschreibung der Mongolen. Teil I: 16-18. Jahrhundert. Otto Harrassowitz, Wiesbaden., 1959
- МУ, УТА, Х99, Д-1, ХН-256

МУ, УТА, Х99, Д-1, Хн-256

二木博史著「白樺法典」『アジア・アフリカ言語文化研究』第21期、1981年、

二木博史著「訳注白樺法典」『モンゴル研究（II）』第12期、1981年、

二木博史著「訳注白樺法典」『モンゴル研究（III）』第14期、1983年、

二木博史著「訳注白樺法典」『遊牧社会史探求（1）』第49期、1976年、

图雅，桦树皮律令文书研究，内蒙古人民出版社，2019年10月

奇格，阿勒坦汗宗教法规述略，内蒙古社会科学，1987年第2期

奇格.古代蒙古法制史[M].沈阳：辽宁民族出版社，1999；

奇格《阿勒坦汗法典》译成汉文，《内蒙古地方志通讯》1983年第4期.

苏鲁格，阿勒坦汗法典，蒙古学信息，1996年第1期，29-35页，第2期

页,奇格，蒙古族法制史概述，内蒙古社会科学，1990年第6期，

<http://www.jstor.org/stable/44027942>

[Abstract]

**Mongolian Legal History Studies: The Current State of Research
on Historical Legal Sources and Contemporary Challenges**

Batbayar Bayanbaatar

Doctor of Laws (Ph.D.).

*Associate Professor at the Public Law Department
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

This article examines the current state, research trends, and several pressing issues in Mongolian legal historical studies, with particular emphasis on the study of traditional legal sources. It clarifies the distinctive nature of legal historical scholarship and highlights its close relationship with source criticism, textology, and other auxiliary disciplines, while underscoring the foundational importance of source-based research in the study of legal history.

In addition, the article provides an overview of the major historical legal sources of Mongolia and assesses the achievements and current level of scholarship in this field. Through selected examples, it also identifies a number of methodological problems that remain evident in the study of certain legal sources. Furthermore, the article evaluates contemporary approaches to legal historical research and argues for the need to strengthen comprehensive source analysis, interdisciplinary collaboration, and more specialized legal studies at the level of particular branches of law.

The study concludes that, although the basic foundations of Mongolian legal historical studies have already been established, there remains a pressing need to advance the field to a new stage through deeper theoretical, methodological, source-critical, and practice-oriented research.

[Keywords]

Mongolian Legal History, Traditional Law, Historical Legal Sources, Source Criticism, Textology, Legal Historical Research.